



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/35

Мөрөн

Үнэлгээний хороо байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 43 дугаар тогтоол, Сангийн Сайдын 2014 оны 212 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 10 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу тус цэцэрлэгт улсын төсвийн урсгал зардлын хөрөнгөөр 29,734,000 (Хорин есөн сая долоон зуун гучин дөрвөн мянган) төгрөгийн төсөвт өртөг бүхий хоол, хүнсний материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог нэгдүгээр, 1,000,000 (Нэг сая) төгрөгийн төсөвт өртөгтэй шатахуун, 7,000,000 (Долоон сая) төгрөгийн түлш, халаалтын материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Худалдан авах ажиллагааг хууль тогтоомж, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Болд)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Арбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч (Д.Уртнасан)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр
сарын 17-ны өдрийн А/35 дугаар
захирамжийн 01 дүгээр хавсралт



АРБУЛАГ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГТ ХООЛ,
ХҮНСНИЙ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ
СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН
(Төсөвт өртөг-29,734,000 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга


Гишүүд: В.Олдох-Аймгийн Хүнсчдийн холбооны дарга

Ж.Балдандорж-Аймгийн Ногоочдын холбооны дарга

З.Отгонбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Н.Шинэбаяр-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр
сарын 17-ны өдрийн А/35 дугаар
захирамжийн 02 дугаар хавсралт



АРБУЛАГ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГТ ШАТАХ
ТОСЛОХ МАТЕРИАЛ, ТҮЛШ ХАЛААЛТЫН МАТЕРИАЛ
НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН
(Төсөвт өртөг-8,000,000 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын
дарга

Гишүүд: В.Олдох-Аймгийн Хүнсчдийн холбооны дарга

Ж.Балдандорж-Аймгийн Ногоочдын холбооны дарга

З.Отгонбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт,
хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Н.Шинэбаяр-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын
Өмчийн хэлтсийн дарга